

**Сонины цахим сан дахь дан бүтэцтэй шинэ
үгийн бүтэц, хэрэглээ**

Үрчгээгийн ШҮРЭЭ*

Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын дээд сургуулийн
докторант, БПК-ийн багш

БАДМА-ОДСЭР**

Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын дээд сургуулийн багш,
доктор (Ph.D), профессор

Хураангуй

Бид тус өгүүлэлдээ 1990-2020 оны хооронд хэвлэгдсэн 31 сониныг сонгон авч, тэдгээр сонины үгийн сангаар цахим сан байгуулж, тухайн цаг үедээ монгол хэлний үгийн санд орж ирсэн шинэ үгсийг бүртгэв. Улмаар нэг үгээс бүтсэн буюу дан бүтэцтэй шинэ үгийг судлан үзэв. Хэрэглэгдэхүүн болгож авсан 31 сонинд бүртгэгдсэн 3099 шинэ үг хэллэгийн дотор дан бүтэцтэй шинэ үг 31.55 хувийг эзэлж байна.

Дагаврын аргаар бүтсэн шинэ үг нь 5.84%-ийг эзэлж, -л, -д, -уул зэрэг цөөн дагавар олонтоо давтагдаж байгаа нь шинэ үг бүтээхэд олон төрлийн дагавар ашиглах нь чухал байгааг илэрхийлж байна.

Үгийн сангийн бүрэлдэхүүний талаас сонины цахим санд нэр үгээс гадна үйл үг олон тохиолджээ. Энэхүү судалгааны ажлын явцад тухайн цаг үедээ “шинэ үг”-ээр хэрэглэгдэж байсан боловч, цаг хугацаа өнгөрөх явцад зарим үг хэллэг хуучирч, үгийн санд ууссан ба зарим үг хэллэг хэрэглэгдэхээ больсон нь ажиглагдлаа.

Түлхүүр үг: сонины хэл найруулга, сонин, үгийн сан, шинэ үг, давтамж, дан бүтэцтэй үг, дагаврын арга, нийгэм хэл шинжлэл

* © Ү.Шүрээ 2024

E-mail: shuree6u@cc.edu.mn

** © Бадма-Одсэр 2024

E-mail: badma_odsar@aliyun.com

1. Удиртгал

Нийгэм хэл шинжлэлийн ухаан бол хүн төрөлхтний хэлийг нийгэм, орчин, хувь хүний онцлогтой холбон судалж, олон шинжлэх ухааны зааг дээр тайлбарладаг, нарийн мэдрэмжтэй, шинэ залуу шинжлэх ухаан юм. Нийгэм хэл шинжлэл нь 1960-аад оноос Америкийн Нэгдсэн Улсад бие даасан салбар ухаан болж хөгжиж эхэлсэн гэж А.М.Селищев, Уриэл Вайнрайх, Уильям Лабов нарын судлаачид үздэг (Оюун, 2020).

Нийгэм хэл шинжлэлийн чиглэлээр дэлхийн улс орнуудын хэл шинжлэлийн эрдэмтэн судлаачид харилцан адилгүй цаг хугацаанд, адил бус түвшинд судалгааны үзэл, онолуудыг дэвшүүлсээр ирсэн бөгөөд нийгэм хэл шинжлэлийн салбарыг бие даасан салбар шинжлэх ухаан болж хөгжихөөс өмнө буюу 1930-1940-өөд оны үеэс Өрнөдийн хэл шинжлэлд хэл хэлэхүйг тодорхойлох, хэлний нийгэмч чанарыг олж илэрхийлэх оролдлогуудыг хийсээр иржээ. Тэдгээрээс төлөөлүүлэн Оросын холбооны улсын судлаач И.А.Бодуэн де Куртенэ, Франц улсын судлаач Ф.Брюно, Швейцарь улсын судлаач Ш.Балли, Бельги улсын судлаач Ж.Вандриес нарыг дурдаж болно. Дээрх судлаачдын судалгаанууд эхлээд хэл шинжлэлийн хүрээнд багтаж байсан боловч, хэлний мөн чанар ба жам ёсыг тайлбарлах тутам хэл нийгэм хоёрын холбоо, онолын судлал болон хөгжиж, улмаар бие даасан судлал болох хэмжээнд хүртэл гүнзгийрсэн байна.

Оросын Холбооны Улсын хувьд В.Д.Бондалетовын “Нийгэм хэл шинжлэл” (Социальная лингвистика), Москва, 1986, Н.Б.Мечковская “Нийгэм хэл шинжлэл” (Социальная лингвистика), В.И.Карасик “Нийгмийн байдал доторх хэл” (Язык социального статуса) Москва, 1991, В.И.Беликов, Л.П.Крысин “Нийгэм хэл шинжлэл” (Социалингвистика) Москва, 2001 зэрэг нэг сэдэвт бүтээлүүд хэвлэгдсэн байна.

Нийгэм хэл шинжлэлийн салбарын хөгжил төлөвшил, хандлага, онол арга зүйн тухай өгүүлсэн хамгийн анхны цогц гарын авлагыг судлаач Мартин Ж.Болл 2010 онд “The Routledge Handbook of Sociolinguistics Around the World” нэртэйгээр хэвлүүлсэн байна. Тэрээр тус номдоо АНУ-аас эхлэн дэлхийн олон улсын хэлний нийгмийн асуудлыг нэг бүрчлэн авч үзэж танилцуулсан байна (Martin J. Ball, Rajend Mesthrie, Chiara Meluzzi, 2023).

Азийн орнуудын хувьд Бүгд Найрамдах Хятад Ард Улсад 1970-1980 оны дунд үеэс нийгэм хэл шинжлэлийн салбар үүсэж, хөгжлийнхөө чигийг тогтоож, Чэн Яан Мин, Чэн Зан Тай, Чэн Ю Ваны нарын судлаачид энэ чиглэлээр гүнзгийрүүлэн судалгаа хийсэн бөгөөд нийгэм хэл шинжлэл бол хэл болон нийгэм зэрэгцэн хувиралцах, хэл болон соёл зэрэгцэн орших үзэгдлийг судалдаг шинжилгээ мөн хэмээн үзжээ (Мөнхбуянт, Элсэнцэцэг, 2017). БНХАУ-ын ӨМӨЗО-ы хувьд судлаач С.Хичээлт “Нийгэм хэл шинжлэлийн удиртгал” (1998), Бадма-Одсэр “Одоо үеийн хэл шинжлэлийн онолын сонгомол” (2012),

Мөнхбуянт, Элсэнцэцэг нар “Нийгэм хэлний шинжлэл” (2017) зэрэг нийгэм хэл шинжлэлийн чиглэлээр тусгайлсан судалгааг хийж өөрсдийн бүтээлүүдээ нийгэм хэл шинжлэлийн судалгааны онол, хүрээ, хэвчээ, судлагдахуун, арга зүйн талаар нэлээд дэлгэрэнгүй бичжээ. Тухайлбал, судлаач Бадма-Одсэр “Нийгэм хэл шинжлэл судлалд нутгийн аялгуу ба журамламал хэл, харь зээллэг үг ба хос хэлийг зэрэгцүүлэн хэрэглэх асуудал, хэлний хувиргалт, хэлний дүрэмчлэл буюу хэм хэмжээ, адилсах мэдрэмж зэргийг судлахаас гадна хоёрдугаар хэл ба завсрын хэл эзэмшихүй, хэлний талаарх бодлого-төлөвшил зэрэг олон зүйлийг багтаан үздэг” (Бадма-Одсэр, 2012) хэмээн тэмдэглэсэн бол Монгол Улсын хувьд судлаач Э.Равданы “Орчин цагийн хэл шинжлэлийн үүд” (Уб, 2005), судлаач Н.Нансалмаагийн “Нийгэм хэл шинжлэл” (Уб, 2019), судлаач Ч.Зэгиймаагийн “Нийгэм хэл шинжлэл” (Уб, 2019), судлаач Ц.Оюуны “Нийгэм хэл шинжлэл судлал” (Уб, 2020) зэрэг бүтээлүүд хэвлэгдсэн нь нийгэм хэл шинжлэлийн судалгаанд үнэтэй хувь нэмрээ оруулжээ.

Нийгэм хэл шинжлэл нь хэлийг соёлын хэм хэмжээ, нөхцөл байдал зэрэг нийгмийн бүх талын нөлөөлөл, хэрэглэх арга зам, нийгэмд үзүүлэх нөлөөлөгч гэдэг талаас нь судлан шинжилж, тайлбарладаг салбар учраас бүх шинжлэх ухааныг холбогч гүүр шинжлэх ухаан хэмээн ойлгож болно. Иймээс шинэ үг үүсэх үйл явц нь тухайн нийгмийнхээ толь учраас энэхүү хэлний үзэгдлийг хэлний нийгмийн талаас буюу нийгэм хэл шинжлэлийн үүднээс судлах нь нэн чухал юм.

Монголын өдөр тутмын сонин хэвлэлийн үгийн санд орж ирсэн шинэ үг хэллэгийг нийгэм хэл шинжлэлийн үүднээс судалсан судалгааны бүтээл олон бий¹ хэдий ч бусад улс орны нийгэм хэл шинжлэлийн салбарын хөгжилтэй харьцуулахад цахим сан байгуулах, цахим санд суурилсан судалгааг хам болон цуваа цагийн үүднээс хийх шаардлагатай байгаа нь харагдаж байна. Иймд бид тус судалгааны ажлын хүрээнд тухайн цаг үедээ монгол хэлний үгийн санд орж ирсэн шинэ үгсийг бүртгэж, улмаар нэг үгээс бүтсэн буюу дан бүтэцтэй шинэ үгийг судлан үзэх зорилго дэвшүүлэв.

2. Судалгааны хэсэг

1990-ээд оноос хойш Монгол Улс хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэмд шилжсэнээр нийгэм, эдийн засаг, улс төр, боловсрол зэрэг нийгмийн бүхий л салбарт олон арван шинэ үг хэллэг монгол хэлний үгийн санд эрчимтэй нэвтрэх болсон билээ. Шинэ үг хэллэг нь хэрэглээ хийгээд нийгэм, цаг хугацаанаас

¹ Ц.Сүхбаатар. Монгол хэлний найруулга зүй. Уб., 1998; ШУА-ХЗХ-ээс эрхэлсэн Хэл соёлын тулгамдсан асуудлууд цуврал №1-ийн Сонины хэл найруулгад хэвлэгдсэн Э.Пүрэвжав. Монгол утга зохиолын хэлний хэл зүйн хэм хэмжээг сонины хэл найруулгад баримтлахын учир холбогдол; Л.Балдан. Сонины хэл найруулгын бүтэц, тогтолцооны асуудал; Л.Болд. “Хүмүүс” сонины нэгэн дугаарт найруулга зүйн үүднээс хийсэн судалгааны зарим дүн; С.Лочин. Сонины гажигтай хэллэг ба зарим нэр томьёо; С.Мөнхсайхан. Сонины хэл найруулгад харь үгийн үүрэг өгүүлүүд болон О.Шинэбаяр. “Нийтлэлийн найруулга”-Монгол хэл судлал, Боть III, Үгийн сан, утга, найруулга судлал. Уб., 2022 гэх зэрэг.

хамааралтай харьцангуй ойлголт бөгөөд тухайн үгийн шинэ сэргэг байх хугацаа нь тухайн үгийн хэрэглээтэй салшгүй холбоотой. Нөгөө талаар үг шинээр буй болсон үеэс нийтийн хэрэгцээт үг болох хүртэлх хугацаанд "шинэ" байна гэсэн үг билээ. Шинэ үг хэллэгийг хамгийн анх олон нийтэд түгээж, танилцуулдаг салбар бол яахын аргагүй хэвлэл мэдээллийн хэрэгсэл байдаг. Иймээс сонины цахим сандаа дараах алхам дарааллаар ажиглалт хийв. Үүнд:

1. Сонины материалын сангаа төрөлжүүлэн ангилах;
2. Материалын сан дахь шинэ үг хэллэгийн бүтцийг тодорхойлох;
3. Өөрсдийн саналыг дэвшүүлж, нэгтгэн дүгнэх зэрэг болно.

2.1 Сонины материалын сангаа төрөлжүүлэн ангилах

Би дэвшүүлсэн зорилгынхоо хүрээнд сүүлийн 30-аад жилийн хугацаанд улс төр, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан, технологи гэсэн хамгийн эрэлттэй таван сэдвийн хүрээнд тогтмол хэрэглэгдэж байгаа үг хэллэгийг тодруулахын тулд “Ардын эрх” сонины 1990-1995 оны 6, “Өдрийн сонин” сонины 1996-2020 оны 25, нийт 31 дугаарын үгийн сангаар цахим санг байгууллаа. Учир нь иргэдийн өдөр тутмын амьдралд хэрэглэгдэж байгаа шинэ үг хэллэгийг нийгэм хэл шинжлэлийн үүднээс гүнзгийрүүлэн судлах ажлын суурь ажил бол 1990-2020 оны хооронд хэвлэгдсэн өдөр тутмын сонины үгийн сангаар цахим сан байгуулах явдал юм. Бидний цахим сан байгуулахаар сонгож авсан сонины дугаарууд нь улиран одсон жилийнхээ ажлыг дүгнэсэн, ирж байгаа жилд бүтээн байгуулах ажлуудаа тоймлон танилцуулсан, тухайн оныхоо онцгой цаг үеийн шинэ ухагдахуун, шинэ мэдээ мэдээллийг хэвлэсэн учир шинэ үг хэллэг цөөнгүй байх магадлалтай хэмээн таамаглал дэвшүүлсний үндсэн дээр тус 31 сонины дугаарыг сонгон авсан юм.

Сонины цахим сангаа дараах аргачлалын дагуу бүрдүүллээ. Үүнд,

- Сонины цаасан эхүүдийг сканераар компьютерт оруулав.
- Бичвэрийг цаасан эхтэй тулгав.
- Сонин тус бүрийн үгийн санг сонины нэр, хэвлэсэн он сар өдөр, сонины дугаарын дагуу ангилан ялгаж, 'Excel Table' болгон хөрвүүлэв.
- Өгөгдлийн сангийн материалыг хэвлэмэл эх хэрэглэгдэхүүнтэй тулгаж, зөв бичих дүрмийн алдааг хянаж, засав.

Бидний байгуулсан 31 сонины үгийн сангийн цахим сангийн үгийн сангийн тооцооллыг үзүүлбэл дараах байдалтай байна. Үүнд,

Хүснэгт №1. 1990-2020 оны сонины үгийн сангийн цахим сангийн хэвчээ

№	Сонины нэр	Он.сар.өдөр	Сонины дугаар	Нийт үгийн тоо
1	Ардын эрх	1990.12.29	Бямба, №72	13150
2	Ардын эрх	1991.12.28	Бямба, №231 (303)	13286
3	Ардын эрх	1992.12.22	Мягмар, №192 (496)	10881
4	Ардын эрх	1993.12.31	Баасан, №219 (719)	9900
5	Ардын эрх	1994.12.31	Бямба, №259 (958)	8425

6	Ардын эрх	1995.12.30	Бямба, №259 (1218)	12597
7	Өдрийн сонин	1996.12.28	Бямба, №038 (038)	13029
8	Өдрийн сонин	1997.12.31	Лхагва, №256 (294)	16966
9	Өдрийн сонин	1998.12.31	Пүрэв, №254 (548)	14022
10	Өдрийн сонин	1999.12.30	Пүрэв, №253 (853)	20260
11	Өдрийн сонин	2000.12.29	Баасан, №1177	14420
12	Өдрийн сонин	2001.12.29	Бямба, №305 (1462)	11607
13	Өдрийн сонин	2002.12.30	Даваа, №306 (1738)	12935
14	Өдрийн сонин	2003.12.30	Мягмар, №307 (2044)	13319
15	Өдрийн сонин	2004.12.30	Пүрэв, №305 (2349)	15496
16	Өдрийн сонин	2005.12.30	Баасан, №305 (2654)	19968
17	Өдрийн сонин	2006.12.29	Баасан, №303 (2957)	16932
18	Өдрийн сонин	2007.12.29	Бямба №305 (3263)	30179
19	Өдрийн сонин	2008.12.30	Мягмар №300 (3563)	14095
20	Өдрийн сонин	2009.12.30	Лхагва №300 (3863)	15819
21	Өдрийн сонин	2010.12.30	Пүрэв, №301 (4164)	34500
22	Өдрийн сонин	2011.12.29	Пүрэв, №300 (4464)	23383
23	Өдрийн сонин	2012.12.28	Баасан, №300 (4764)	17787
24	Өдрийн сонин	2013.12.27	Баасан, №300 (5094)	32284
25	Өдрийн сонин	2014.12.30	Мягмар, №300 (5394)	19824
26	Өдрийн сонин	2015.12.28	Лхагва, №300 (5993)	21337
27	Өдрийн сонин	2016.12.28	Лхагва, №300 (5993)	18012
28	Өдрийн сонин	2017.12.28	Лхагва, №300 (5993)	21869
29	Өдрийн сонин	2018.12.28	Баасан, №251, 252 (6545)	34,837
30	Өдрийн сонин	2019.12.30	Даваа, №257 (6802)	28,287
31	Өдрийн сонин	2020.12.30	Лхагва, №246 (7048)	28,431

Үгийн сангийн тооцооллоос үзвэл, бидний бүрдүүлсэн санд 577,837 үг бүртгэгдлээ. Сонины цахим сан тус бүрийн үгийн санг харьцуулж үзвэл, хамгийн их үгтэй сан нь “Өдрийн сонин”-ы 2018 оны 12 сарын 28-ны баасан гаргийн №251, 252 (6545) дугаартай сонин байв. Тус сонины санд 34,837 үг бүртгэгдсэн байна. Хамгийн бага үгтэй сан нь “Ардын эрх” сонины 1994 оны 12 сарын 31-ний бямба гаргийн №259 (958) дугаартай сонин байв. Тус сонины санд 8425 үг бүртгэгдсэн байна. Энэ нь мөн сонины нүүрийн тоотой уялдаад үгийн тоо их, бага янз бүрийн хэмжээтэй байгаа болно. Мөн ижил нүүртэй сонинуудын үгийн тоо харилцан адилгүй байгаа нь зураг материалын хэмжээтэй холбоотой байна.

2.2 Материалын сан дахь шинэ үг хэллэгийн бүтцийг тодорхойлох

Бид судалгаандаа судлаач Т.Батбямбын² тусламжтайгаар эх хэлний боловсруулалтад өргөн хэрэглэдэг “Онцлогийг тодорхойлох арга” (Attribute Description Method)-аар материалын сандаа тэмдэг хадсан бөгөөд шинэ үг

² ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Компьютер хэл шинжлэлийн лабораторийн ЭШДЭА.

хэллэгийн цахим сангаа бүрдүүлэхдээ дэс дугаар, сонины нэр, сонины дугаар, булангийн нэр, шинэ үг хэллэг, үгийн сангийн тоо, шинэ үг хэллэгийн бүтэц, шинэ үг хэллэгийн бүрэлдэхүүний тоо (үгийн тоо) гэсэн найман зүйлээр ялган ангилж, тохирох хэмжигдлийн үр дүнг тэмдэглэлээ.

Мөн материалын санд бүртгэгдсэн шинэ үг хэллэг нь хэдэн үгээс бүтсэнийг тооцоолохдоо зарим нэр үгийн тийн ялгал болон хамаатуулах зэрэг салангид бичигддэг нөхцөлүүд дээр тэмдэг хадаж, тооцооллыг $=IF(LEN(TRIM(B2))=0,0, LEN(TRIM(B2))-LEN(SUBSTITUTE(B2," ",""))+1)$ томъёогоор гаргав.

Хүснэгт №2. Дан бүтэцтэй шинэ үг хэллэгийн тооцоолол

№	Сонины нэр	Он.сар.өдөр	Шинэ үг хэллэгийн тоо	Дан бүтэцтэй шинэ үгс	Жишээ нь
1	Ардын эрх	1990.12.29	81	12	Дамчид
2	Ардын эрх	1991.12.28	72	15	Аэробик
3	Ардын эрх	1992.12.22	82	18	ТОФЕЛ
4	Ардын эрх	1993.12.31	63	23	нотариат
5	Ардын эрх	1994.12.31	73	23	продюссер
6	Ардын эрх	1995.12.30	89	35	баар
7	Өдрийн сонин	1996.12.28	70	24	монополчлол
8	Өдрийн сонин	1997.12.31	162	57	пицца
9	Өдрийн сонин	1998.12.31	144	10	патиар
10	Өдрийн сонин	1999.12.30	115	5	камер
11	Өдрийн сонин	2000.12.29	80	2	тендер
12	Өдрийн сонин	2001.12.29	94	4	менежер
13	Өдрийн сонин	2002.12.30	89	1	шоу
14	Өдрийн сонин	2003.12.30	73	32	Ченж
15	Өдрийн сонин	2004.12.30	104	42	CV
16	Өдрийн сонин	2005.12.30	116	60	сенсac
17	Өдрийн сонин	2006.12.29	56	27	супермаркет
18	Өдрийн сонин	2007.12.29	104	59	хаус
19	Өдрийн сонин	2008.12.30	108	48	бойкот
20	Өдрийн сонин	2009.12.30	79	30	бонд
21	Өдрийн сонин	2010.12.30	111	56	камержуулах
22	Өдрийн сонин	2011.12.29	162	59	АТМ
23	Өдрийн сонин	2012.12.28	72	29	аппликэйшн
24	Өдрийн сонин	2013.12.27	60	27	пентхаус
25	Өдрийн сонин	2014.12.30	95	35	лоунж
26	Өдрийн сонин	2015.12.28	63	24	паспортжуулах
27	Өдрийн сонин	2016.12.28	108	52	хандивлагч
28	Өдрийн сонин	2017.12.28	85	43	лизинг

29	Өдрийн сонин	2018.12.28	126	56	шок
30	Өдрийн сонин	2019.12.30	114	36	чип
31	Өдрийн сонин	2020.12.30	248	34	цахимжуулах

Бүртгэлээс үзвэл, сонины цахим санд буй 577,837 үгийн 3099 нь шинэ үг хэллэг байна. Шинэ үг хэллэгийн 978 буюу 31.5 хувь нь “номинаци”, “таун”, “лообийдож”, “траншейн”, “жиргээ” зэрэг дан бүтэцтэй, үлдсэн 68.5 хувь нь “хар машин”, “найман хувийн хүүтэй зээл”, “бурханч лам”, “стратегийн түншлэл” зэрэг нийлмэл бүтэцтэй байна.

Тэгвэл дан үгээс бүтсэн шинэ үгийг тусгайлан авч үзье. Монгол хэл нь залгамал бүтэцтэй бөгөөд язгуурын араас дагавар залгаж үндэс үүсгэх, нөхцөл залгаж үг хувилгадаг онцлогтой. Энэ шинжийг шинэ үг бүтээх боломжийн талаас харахад нугалмал болон тусгайлаг хэв шинжийн хэлнээс хязгаарлагдмал байдалтай. Учир нь, монгол хэлний үгийн язгуурын өмнө угтвар болон угтвар үгийг залган шинэ үг үүсгэдэггүйтэй холбоотой. Монгол хэлний бүтцийн онцлогоос хамаарч үг бүтээх түүнчлэн шинэ нэр томьёо бүтээх үндсэн арга нь язгуурт дагавар залгах нийлэг арга, хоёр өөр язгуур нийлж шинэ үг бүтээх задлаг арга гэдгийг судлаачид нэгэнт тогтоожээ (Батбямба., 2023).

Стандартчилсан нэр томьёоны сан дахь үгээ судлаач Г.Гэрэлмаагийн (Г.Гэрэлмаа, 2020) тодорхойлсноор нийлэг болон задлаг аргаар бүтсэн гэж хуваагаад нийлэг аргаар үүссэн үгэнд бас тоон судалгаа хийв.

Шинэ үгсийг бүтээсэн дагаврын тооцооллыг тусгайлан гаргавал:

- чин: (наймаачин, дамчин)
- д: (дамчид, хандивлагчид)
- л: (цагаачил, борлуул, түншлэл, хөнгөлөл, форматлах, түрээслүүлнэ)
- л: (глобалчлал, монополчлол, даяарчлал, түншлэл, хямдрал, урамшуулал)
- уул2: (индексжүүлэх, чихдүүлэх, улстөржүүлэх, урамшуулал, камержуулах)
- ууд2: (одууд)
- рх: (зиндаархах)
- ээс4: (түрээсийнхэн)
- чил: (монополчил, ардчил, автоматчил, хувьчил, глобалчил)
- д: (рекламд, хулхид, архид, порогонд, чихэд, шоуд, луйвард, сканерд)
- р: (дампуур, хямдар, ядуур)
- бар4: (хуулбар)
- лт: (борлуулалт, архидалт, хөнгөлөлт, камержуулалт)
- гч: (хандивлагч, манлайлагч, импортлогч, хамгаалагч, ангижруулагч, илтгэгч)
- ж: (улстөрч, цахимч)
- гүй: (ажилгүй)
- дэл: (ажилгүйдэл)
- гэ: (сэргээ)

- ээ: (сэргээ)
- ш: (сэргээш)
- ш: (урамш) гэх мэт болно.

Тооцооллоос үзэхэд, сонины цахим санд илэрсэн шинэ үгсийн ихэнх нь үйлээс нэр үг бүтээх -л, -гч болон нэрээс үйл үг бүтээх -л, -д дагавар залгаж бүтсэн байна. Үүнийг бид үгийн сангийн шинэ үг бүтээхэд ч дээрх дагавруудын хэрэглээ өндөр байдагтай холбож ойлгож байна.

Мөн санд буй монгол хэлний хэл зүйгээр хэлбэржсэн гадаад шинэ үгэнд ажиглалт хийвэл:

- уул2: (индексжуул, камержуул)
- л: (экспортол, форматал)
- л: (глобалчлал, монополчлол)
- чил: (монополчил, автоматчил)
- д: (рекламд, шоуд, сканерд)
- лт: (камержуулалт)
- ж: (паспортжуулж) гэх мэт байна.

Дээрх шинэ үгсийг ажиглахад, вакцинжуулах, колоничлол, коронадох, конторлох, балансжих зэргээр харь хэлний үгсийг хэл зүйн хувиллаар хувилгаж, монгол хэлнээ нутагшуулан хэрэглэж байгаа нь шинэ үг хэллэг нь явцуу хэрэглээнээс өргөн хэрэглээний үг хэллэг болж байгааг харуулж байна.

Дүгнэлт

Бидний сонгож авсан сонины дугаарууд нь тухайн жилийнхээ үйл явдлыг дүгнэж, онцгой цаг үеийн тухай мэдээлсэн учир шинэ үг олон бүртгэгдэв.

Сонины цахим сангаас үзэхэд, нийгмийн доторх цөөн тооны хэсэг бүлэг хүмүүсийн хэлэлцэх, ихэвчлэн мэргэжлийн онцлогтой холбоотойгоор үүссэн “домофон систем”, “дохиоллын систем”, “бүрэн автомат цоож” зэрэг зөвхөн тэдний дунд л нэлээд ойлгомжтой байж чадах тийм үг хэллэгүүд аажмаар хүмүүсийн шинжлэх ухааны янз бүрийн салбарын мэдлэг өргөжиж байгаатай холбогдон олон нийтийн дунд идэвхтэй хэрэглэгдэх болсон байна. Мөн “оффшор”, “гомо”, “лиценз”, “бонус” зэрэг зарим үг хэллэгийн хэрэглээний байдал өнөө хэр нь идэвхтэй байгаа бол, “интернэт”, “караоке”, “кабель”, “дампуурал” зэрэг зарим үгсийн хувьд өөр үгээр хэрэглэгдэх байдалтай болсон буюу хэрэглээнээс гарсан байна.

Сонины цахим санд илэрсэн дан бүтэцтэй шинэ үгсийн 5.84 хувийг дагаврын аргаар, үлдсэн 94.16 хувийг үндсээрээ байгаа үг эзэлсэн нь дээрх шинэ үгс хэлний хэмнэлт, хэм хэмжээ зэргийг өөртөө бүрэн шингээснийг илтгэж байна. Түүнчлэн гадаад үгэнд дагавар залгаж бүтсэн дан бүтэцтэй үгс цөөн бүртгэгдсэн нь шинэ үг хэллэгийг аль болох монгол үгээр оноон тогтоохыг эрмэлзэж буйг илтгэн харуулж байна.

Үгийн сангийн бүрэлдэхүүний талаас сонины цахим санд нэр үгээс гадна үйл үг олон тохиолджээ. Энэхүү судалгааны ажлын явцад тухайн цаг үедээ “шинэ үг”-ээр хэрэглэгдэж байсан боловч, цаг хугацаа өнгөрөх явцад зарим үг хэллэг хуучирч, үгийн санд ууссан ба зарим үг хэллэг хэрэглэгдэхээ больсон нь ажиглагдлаа. Иймд өдгөө “шинэ, соргог” утгаа алдахгүй хэрэглэгдэж байгаа үгсийг “халуун үгс” хэмээн нэрлэдэг судлаачдын саналыг дэмжих саналтай байна.

Цаашид бидний судалгааг монгол хэлний үгийн харь үгийн судалгаа, үгийн гарлын судалгаа, нэр томьёоны судалгаа зэрэг бусад судалгаануудтай хослуулан үзэхийн зэрэгцээ ижил төрлийн цахим хөмрөгүүдийг үүсгэж, гүнзгийрүүлэн судлах шаардлагатай юм.

Талархал

Тус өгүүлэл нь Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын дээд сургуулийн багш, доктор (Ph.D), профессор Бадма-Одсэрийн удирдаж байгаа Хятадын нийгмийн шинжлэх ухааны фондын том төсөл ITCDA316 “Монголчуудын хэлний амьдралын хээрийн шинжилгээ” төслийн хүрээнд бичсэн судалгааны ажлын нэг хэсэг юм.

Сонины хөмрөг бүрдүүлэхэд хамтран ажилласан Монголын Үндэсний Номын сангийн хамт олонд талархлаа илэрхийлье.

Мөн энэхүү өгүүллийг бичихэд арга зүйн зөвлөгөө өгч, удирдан чиглүүлсэн Бадма-Одсэр багшдаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Abstract:

We selected 31 newspapers printed between 1990 and 2020, created an electronic corpus using the vocabulary of those newspapers, and recorded new words that entered the Mongolian vocabulary at that time in this article. Subsequently, a new word composed of one or single word was studied. Among the 3099 new words registered in 31 newspapers, new words with a single structure account for 31.55 percent.

New words formed by affixation accounted for 5.84%, and few affixes such as -l, -d, and -ul are frequently repeated, which means that it is important to use a variety of affixes to create new words.

There are many verbs in addition to nouns in the electronic corpus of newspapers in terms of vocabulary. In the course of this research, it was observed that some words were used as “new words” at that time, but with the passage of time, some words became archaic and merged into the vocabulary, and some words were no longer in use.

Keywords: newspaper stylistic, newspaper, vocabulary, new words, frequency, single words, subjunctive method, sociolinguistics

Ном зүй

- Бадма-Одсэр.** (2012). *Одоо үеийн хэл шинжлэлийн онолын сонгомол*. Хөх хот: Өвөрмонголын хэвлэлийн хороо. [Badma-Odser. *Odoo üyeiin khel shinjleliin onolyn songomol*. Khökh khot: Övörmongolyn khevleliin khoroo. [Badma-Odser. A selection of contemporary linguistic theories.] Khokhloma: Inner Mongolia Publishing.]
- Базаррагчаа, М., Пүрэвжал, Ч.,** (1984). *Монгол хэлний үйл үгийн байдал ба болцын тухай*, Studia Mongolica (20) Улаанбаатар. [Bazarragchaa, M., Pürevjal, Ch., *Mongol khelnii үйл үгийн baidal ba boltsyn tukhai*, Studia Mongolica (20) [Bazarragchaa, M., Purevzhal, Ch., On the status and conjugation of verbs in the Mongolian language, Studia Mongolica (20)] Ulaanbaatar.]
- Балдан, Л.,** (2002). *Хэл соёлын тулгамдсан асуудлууд цуврал №1*. Эрхэлсэн: Хэл зохиолын хүрээлэн, Сонины хэл найруулгын бүтэц, тогтолцооны асуудалд. Улаанбаатар: Бемби сан хэвлэлийн газар. [Baldan, L., *Khel soyolyn tulgamdsan asuudluud tsuvral №1*. Erkhelsen: Khel zokhiolyn khüreen, Soniny khel nairuulgyn бүтэц, togtoltsoony asuudald. Ulaanbaatar: Byembi san khevleliin gazar. [Baldan, L., Current issues of language and culture series No. 1. Organized by: Institute of Language and Literature, On the structure and system of newspaper language composition.] Ulaanbaatar: Bembi San Publishing.]
- Барайшир, Ш.,** (1972.08.04). *Сонин хэвлэл, радио нэвтрүүлгийн хэл найруулгын асуудалд*. Үнэн, 6 нүүр. [Baraishir, Sh., *Sonin khevel, radio nevtrүүлгийн khel nairuulgyn asuudald*. *Ünen*, 6 нүүр. [Barayshir, Sh., On the problems of language composition in newspapers and radio broadcasts. Truth, 6 pages.]
- Батбямба, Т., Алтантуяа, С., Алтангэрэл, Ч.,** (2022). *ЕБС-ийн I ангийн монгол хэлний сурах бичгийн үгийн сан, үгийн хувиллыг цахим хэл шинжлэлийн үүднээс бүртгэн судалсан нь*. Хэрэглээний хэл шинжлэл сэтгүүл, Боть (VI)21, Дэвтэр 1-18, Улаанбаатар: Соёмбо принтинг. [Batbyamba.T, Altantuya.S, Altangerel.Ch, *YEBS-iin I angiin mongol khelnii surakh bichgiin үгийн сан, үгийн khuvillyg tsakhim khel shinjleliin үүдnees бүртген судалсан ni*. [An Applied Linguistic Study on Lexical and Grammatical Levels for Mongolian Language Textbook of the First Grade at the Secondary School in Mongolia. Applied Linguistics, 2021, 22: 89-102.] Ulaanbaatar: Soyombo printing].
- Батбямба, Т., Ариун-Онон, Г., Мөнхсайхан, С.,** (2022). *Монгол улсын үндсэн хуулиудын үгийн сангийн давтамжийг харьцуулсан нь*. Соёлын жимээр сэтгүүл, Боть II, Бэмби сан ХХК. [Batbyamba, T., Ariun-Onon, G., Mönkhsaikhаn, S., *Mongol ulsyn үндсэн khuuliudyn үгийн sangiin davtamjiig kharitsuulsan ni*. Soyolyn jimeer setgүүл, Boti II, Bembi san. [Batbyamba, T., Ariun-Onon, G., Munkhsaikhаn, S., Comparing the frequency of vocabulary in the constitutions of Mongolia. Journal of Cultural Studies, Vol. II,] Ulaan-

- baatar: Bembi san printing.]
- Батбямба, Т.,** (2023). Стандарт дахь нэр томьёоны бүтцэд хийсэн тоон шинжилгээ. Хэрэглээний хэл шинжлэл сэтгүүл, Боть VIII (23), Дэвтэр 1-13, Улаанбаатар: Соёмбо принтинг. [Batbyamba, T., Standart dakhi ner tomiyoony büttseel khiisen toon shinjilgee. Kheregleenii khel shinjlel setgüül, Boti VIII (23), Devter 1-13, Ulaanbaatar: Bembi san printing. [Batbyamba, T., Quantitative analysis of the structure of terms in standards. Journal of Applied Linguistics, Vol. VIII (23), Issues 1-13, 2023, 13: 13-25] Ulaanbaatar: Soyombo Printing.]
- Баттөгс, Ш., Пүрэвжав, Э. Түвшинтөгс, Б., Гэрэлмаа, Г., Шинэбаяр, О., Ганболд, Д.** (2022). *Үгийн сан, утга, найруулга судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Battögs, Sh., Pürevjav, E. Tüvshintögs, B., Gerelmaa, G., Shinebayar, O., Ganbold, D. *Ügiin san, utga, nairuulga sudlal*. Ulaanbaatar: Soyombo printing. [Battogs, Sh., Purevjav, E. Tuvshintogs, B., Gerelmaa, G., Shinebayar, O., Ganbold, D. Study of vocabulary, meaning, and composition.] Ulaanbaatar: Soyombo Printing.]
- Вандуй, Э.,** (1965.07.02.). *Орчин цагийн монголын утга зохиолын хэлний нормын асуудал*. Үнэн, 6 нүүр. [Vandui, E., *Orchin tsagiin mongolyn utga zokhiolyn khelnii normy asuudald*. Ünen., 6 nüür. [Vanduy, E., On the problems of the norms of the modern Mongolian literary language. Truth. , 6 pages.]
- Ганбаатар, Ж.** (2016). *Орчин цагийн монгол хэлний үг бүтээх дагаврын байрлалын судалгаа* (Хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл). Улаанбаатар. [Ganbaatar, J. *Orchin tsagyn mongol helnii üg бүteeh dagawriin bairlaliin sudalgaa* (Hel shinjleliin uhaany doctor (Ph.D)-iin zereg gorilson бүteel) [Analyze on the Allocation of Word Formation Suffix in Modern Mongolian Doctoral Dissertation]. Ulaanbaatar. 2016.]
- Ганбаатар, Ж.,** (2020). *Үйлээс үйл үг бүтээх дагаврын байрын тогтолцоо*, Монгол судлал эрдэм шинжилгээний цуврал, Vol. 44 No. 543, Улаанбаатар: Соёмбо принтинг. [Ganbaatar, J., *Üilees үil үg бүteekh dagavryn bairyn togtoltsoo*, Mongol sudlal erdem shinjilgeenii tsuvral, Vol. 44 No. 543, Ulaanbaatar: Soyombo printing. [Ganbaatar, J., The system of suffixes in the formation of verbs from verbs, Mongolian Studies Research Series, Vol. 44 No. 543,] Ulaanbaatar: Soyombo Printing.]
- Гэрэлмаа, Г.,** (2020). *Монгол хэлний нэр томьёо бүтэх нийлэг болон задлаг хэв шинж*, Улаанбаатар: Соёмбо принтинг. [Gerelmaa, G., *Mongol khelnii ner tomiyoo бүtekh niileg bolon zadlag khev shinj*, Ulaanbaatar: Soyombo printing. [Gerelmaa, G., The synthetic and deductive patterns of the formation of Mongolian terms,] Ulaanbaatar: Soyombo Printing.]
- Мөнхбуянт., Элсэнцэцэг.,** (2017). *Нийгэм хэлний шинжлэл*. Хөх хот: Өвөрмонголын хэвлэлийн хороо. [Mönkhbuyant., Elsentsetseg., *Niigem khelnii shinjlel*. Khühk khot: Övörmongolyn khevleliin khoroo [Munkhbuy-

ant., Elsentsetseg., Sociolinguistic analysis.] Khokh city: Inner Mongolia Publishing Committee.]

Мөнхцэцэг. Н., Гэрэлмаа. Г., Шинэбаяр О., Золжаргал. Б., Амартүвшин. Н., Батбямба. Т., Даваасүрэн. Т., Гэндэнпил. Х., (2024). *Стандартчилсан нэр томъёоны бүтэц, бүрэлдэхүүн*, Монгол нэр томъёоны стандартын судалгаа, Улаанбаатар: Наран зон принт. [Mönkhtsetseg. N., Gerelmaa. G., Shinebayar O., Zoljargal. B., Amartüvshin. N., Batbyamba. T., Davaasüren. T., Gendenpil. Kh., *Standartchilsan ner tomiyoony бүтэц, бүрэлдэхүүн*, Mongol ner tomiyoony standartyn sudalgaa, Ulaanbaatar: Naran zon print. [Munkhsetseg. N., Gerelmaa. G., Shinebayar O., Zoljargal. B., Amartuvshin. N., Batbyamba. T., Davaasuren. T., Gendenpil. H., Structure and composition of standardized terms, Research on Mongolian term standards,] Ulaanbaatar: Naranzon Print.]

Насан-Урт, С., (2004). *Монгол хэл бичгийн сураг занги боловсруулах онол практикийн зарим асуудал*. Улаанбаатар : Адмон принт. [Nasan-Urt, S., *Mongol khel bichgiin surag zangi bolovsruulakh onol praktikiin zarim asuudal*. Ulaanbaatar: Admon print. [Nasan-Urt, S., Some theoretical and practical issues of developing Mongolian written forms.] Ulaanbaatar: Admon Print.]

Оюун, Ц., (2020). *Нийгэм хэл шинжлэл судлал*. Улаанбаатар хот: Соёмбо принтинг ХХК. [Oyun, Ts., *Niigem khel shinjlel sudlal*. Ulaanbaatar khot: Soyombo printing [Oyun, Ts., Sociolinguistics.] Ulaanbaatar: Soyombo Printing LLC.]

Шинэбаяр, О., (2022). *“Нийтлэлийн найруулга”- Монгол хэл судлал*, Боть III, Үгийн сан, утга, найруулга судлал. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Shinebayar, O., *“Niitleliin nairuulga”- Mongol khel sudlal*, Boti III, Ügiin san, utga, nairuulga sudlal. Ulaanbaatar: Soyombo printing [Shinebayar, O., “Publication composition” - Mongolian language studies, Volume III, Vocabulary, meaning, composition study.] Ulaanbaatar: Soyombo Printing.]

Цахим эх сурвалж

Anthony, L. (2002). <https://www.laurenceanthony.net/software/antconc/>. Retrieved from Laurence Anthony's AntConc: <https://www.laurenceanthony.net/software/antconc/>

1. Martin J. Ball, Rajend Mesthrie, Chiara Meluzzi. (2023, 7 28). <https://www.taylorfrancis.com/books/edit/10.4324/9781003198345/routledge-handbook-sociolinguistics-around-world-martin-ball-rajend-mesthrie-chiara-meluzzi>



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.